

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГАА-2023/30-ШТА-НА

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ХУУЛЬ,
ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Сүрэнжаргал

Утас: 70533552 Цахим хаяг: surenigarnald@audit.gov.mn

Аудитор Т.Будсрэн

Утас: 70533552 Цахим хаяг: budsurent@audit.gov.mn

Аудитор Э.Бат-Эрдэнэ

Утас: 70533552 Цахим хаяг: bat-erdeneer@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр	Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын менежер: Т.Хонгорзул	Хүснэгт, графикийн жагсаалт	3-4
Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4-5
Аудитор: Т.Будсүрэн Э.Бат-эрдэнэ	Ерөнхий мэдээлэл	6
	Бүлэг 1. Аймгийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна.	6
	А.1. Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгийг баталж хэрэгжүүлсэн байна,	6-8
	А.2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр харилцааг тусгаж, дүгнэсэн байна.	8-9
		9
	Бүлэг 2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хууль, журмын дагуу хэрэгжээгүй байна.	
	Б.1 Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт журмын дагуу хэрэгжихгүй байна.	9-12
2023 оны 05 дугаар сар	Б.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 16.1 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна	12-15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээгүй байна.	15
Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	В.1 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна	15-16
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот	В.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт, хийж үр дүнг дүгнээгүй байна.	16-17
	Дүгнэлт	17
	Холбогдох байгууллагын санал	18
	Дарга, Тэргүүлэх аудиторовын тушаал	19
		20
	Хавсралт №1	21
	Хавсралт №2	22-23
	Хавсралт №3	24-25
	Хавсралт №4	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
УИХ	Улсын Их хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АНТАГ	Аймаг, нийслэлийн Төрийн аудитын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
БИОФИН	Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин аялал, жуулчлалын газар
БОХТХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ

Хүснэгт, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Аймгийн бодлогын баримт бичиг тусгасан арга хэмжээ	6
Хүснэгт 2	Аймгийн БНАТ-ийн орлогоос БОХНС арга хэмжээнд зарцуулах доод дүн, гүйцэтгэл	6
Хүснэгт 3	Сумдын БНАТ-ийн орлогоос БОХНС арга хэмжээнд зарцуулах доод дүн	8
Хүснэгт 4	2021-2023 онд агнах амьтдын зөвшөөрлийн тоо	
Хүснэгт 5	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг	
Хүснэгт 6	Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд хийсэн 130 арга хэмжээний 105 арга хэмжээ нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдаж 25 арга хэмжээ	
Хүснэгт 7	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 2021-2022 оны гүйцэтгэл	
Хүснэгт 8	http://eic.mn/finance/ цахим системийн мэдээ оруулалтын байдал	
Хүснэгт 9	Усны нөөц ашиглалтын мэдээллийн зөрүү	
График 1	Нөөцийн төрлөөр БНАТ-ын орлого, БОХНСАХ-ий зарцуулалтад эзлэх хувь	
График 2	Гэрээний хэрэгжилтийн үнэлгээний байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан хэсгийг 2021, 2022 оноор харьцуулалт	5
График 3	Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийн үнэлгээний байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй	

График 4	холбогдох харилцааг тусгасан хэсгийг 2021, 2022 оноор харьцуулалт	
	Аймаг, нийслэлийн Засаг дарга БОАЖГ-ын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	12
График 5		13
	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2021-2022 оны зарцуулалтын эзлэх хувь	13
График 6		13
	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд төсвийг зориулалт бусаар зарцуулсан гүйцэтгэлийн хувь	
График 7		
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлаас зориулалт бусаар санхүүжүүлсэн арга хэмжээний эзлэх хувь	

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай

	ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Хамрах хүрээ:	Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Усны сав газрын захиргаа, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Хүндрэл, бэрхшээл:	Аудитын гүйцэтгэлийн үе шатанд судалгааны маягт өөрчлөгдсөн, Татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл зөрүүтэй, усны нөөц болон татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжийн мэдээлэл нууцад хамаардаг шалтгаанаар холбогдох газраас мэдээлэл ирүүлээгүй болно.
Аудитад ашигласан шалгуур:	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд: • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль • Хууль тогтоомжийн тухай хууль • Байгаль орчныг хамгаалах тухай хууль • Ойн тухай хууль • Усны тухай хууль • Амьтны тухай хууль • Газрын тухай хууль • Байгалийн ургамлын тухай хууль • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль • Төсвийн тухай хууль • Шилэн дансны тухай хууль • Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам • Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр • Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл • Өмнөговь аймгийг 2021, 2022, 2023 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө • Менежментийн төлөвлөгөөнүүд • Судалгаа
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор Д.Сүрэнжаргал, аудитор Т.Будсүрэн, Э.Бат-эрдэнэ нар 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.


Ерөнхий мэдээлэл

Өмнөговь аймгийн хувьд БНАТ-ийн орлогын гүйцэтгэлийг 2021, 2022 онуудад төвлөрүүлсэн нийт орлогын 60.9 хувь нь ус, 36.8 хувь нь газар, 2.2 хувь нь амьтан, 0.02 хувь нь байгалийн ургамал ашигласны төлбөр байна.

Ойн нөөцийн төрлөөр орлого байхгүй ба БОХНСАХ-д орон нутгийн төсвөөр санхүүжүүлж байна.

БОХНСАХ-нд 2021, 2022 онуудад зарцуулсан нийт төсвийн хөрөнгийн 65.8 хувийг ус, 23.3 хувийг ой, 7.4 хувийг газар, 3.4 хувийг амьтан, 0.1 хувийг байгалийн ургамал эзэлж байна.

График №1 Нөөцийн төрлөөр БНАТ-ын орлого, БОХНСАХ-ий зарцуулалтад эзлэх хувь



Эх сурвалж: СТСХ-ийн мэдээ, БОАЖГ-ын тайлан мэдээ, татварын газрын мэдээ, сав газрын захиргааны тайлан мэдээ

Зарцуулалтын ихэнх хувийг эзэлж байгаа усны төрөл 2021 онд 17,000,260.3 м3 ус ашиглаж байсан бол 2022 онд 18,650,579.5 м3 ус болж 1,650,319.2 м3 буюу 9.7 хувиар өссөн байна.

Нийт ус ашиглалтын 90 хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар тэр дундаа Оюутолгой, Энержи ресурс, Эрдэнэс таван толгой, Монголын Алт Мак компаниуд эзэлж байна.

БҮЛЭГ 1 Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт хангагдсан байна

А.1. Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгийг баталж хэрэгжүүлсэн байна

А.1.1 Байгалийн нөөц ашигласны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дах заалтыг үндэслэн Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг баталсан.

Тус журмын хэрэгжилттэй холбоотой дараах өөрчлөлтийг оруулах саналтай байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “сум, дүүргийн байгаль хамгаалагч байгалийн нөөц ашигласны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавих”, 23.2-д “байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтын тайланг дараа сарын 10-ны дотор сум, дүүргийн байгаль хамгаалагч харьяалагдах татварын албанд тайлагнаж илгээх” заалтыг оруулах,

- “Сумын Засаг даргын дэмжсэн бичиг” гэсэн заалтыг Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 заалт дээр нэмэх,
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалд “тэсрэх бодис үйлдвэрлэхэд шаардагдах усны норм”-ыг хавсралтаар оруулах,
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2013 оны 156 дугаар тушаалд “уул уурхайн шүүрлийн усан дээр өвлийн улиралд усны тоолуур суурилуулах шаардлага”-ыг нэмэх,
- Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 7в-д “уул уурхайн компаниудын 90 гаруй хувь усыг шавхан зайлуулах уснаас ашигладаг хувийг нэмэгдүүлэх” -ийг 40 хувиар өөрчлөх саналтай байна.

A.1.2 Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/3, 2/4 дүгээр тогтоолоор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлан дараах зорилтуудыг тусгасан байна.

- Говь цөлийн бүсийн байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр үлдээх, байгаль орчны хөгжлийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, хяналтыг сайжруулна.
- Байгаль орчныг хамгаалах, байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэлийг боловсронгуй болгож баяжуулах, мэдээллийн шуурхай байдал, харилцан уялдаа холбоог сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Усны нөөц сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, гадаргын усыг хуримтлуулж хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хамгаалах усны нөөцийн зохистой менежментийн бодлого хэрэгжүүлж, ногоон бүс байгуулах санал санаачлалыг дэмжинэ.
- Нэн ховор, ховор амьдыг хамгаалах, нутагшуулан үржүүлэх, тархац нутаг амьдрах орчныг сайжруулж, устаж үгүй эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд аймгийн 2021, 2022, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 71 төсөл арга хэмжээ буюу 37,059.6 сая төгрөг төлөвлөснөөс аймгийн ИТХ-аар 62 төсөл арга хэмжээ буюу 30,140.4 сая төгрөг баталсан байна.

Хүснэгт №1 Аймгийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээ

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд			Аймгийн ИТХ-аас баталсан төсөл арга хэмжээ		Үүнээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	
Он	Зорилт, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Тоо	Дүн	Тоо	Дүн
2021	19	3,261.1	12	6,944.0	7	5,684.5
2022	29	17,716.1	27	10,940.0	15	5,660.2
2023	23	16,082.4	23	12,256.4	13	5,644.1
Дүн	71	37,059.6	62	30,140.4	35.0	16,988.8

Эх сурвалж: 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын тогтоолууд

Хүснэгтээс харахад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 35 арга хэмжээ буюу 16,988.8 сая төгрөгийг 2021-2022 онуудад аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулсан байна.

A.1.3 Аймгийн хэмжээнд Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө, Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Ойн менежментийн төлөвлөгөө, Агнуурын нөөц бүхий аймгийн ан агнуурын


“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

менежментийн төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг холбогдох яамд, аймгийн ИТХ-ын тогтоолоор байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээнүүдийг тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

А.2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

А.2.1 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2021 онд хамтран ажиллах гэрээнд 9 зорилтын хүрээнд 55 заалт арга хэмжээ, 2022 онд 9 зорилтын хүрээнд 90 заалт арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг дүгнэсэн байна.

График №2 Гэрээний хэрэгжилтийн үнэлгээний байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан хэсгийг 2021, 2022 оноор харьцуулан харуулбал:



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2021, 2022 оны гэрээний үүргийн биелэлтийн жилийн эцсийн тайлан

Графикаас харахад байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг 2021 онд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ буюу хэрэгжилт 93.7 хувьтай, 2022 онд 4 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ буюу хэрэгжилт 87.2 хувьтай байна.


Коронавируст халдвар болон цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2021 онд 0-30 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ байна. Тухайлбал:

- Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах-2
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх-1
- Салбар дундын зохицуулалт, уялдааг хангаж хамтарч ажиллах-1

А.2.2 Аймгийн Засаг дарга 15 сумдын Засаг дарга нартай 2021, 2022 онд хамтран ажиллах гэрээнд байгаль орчны чиглэлээр 1 зорилтын хүрээнд 5 заалт арга бүхий хэмжээнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох 3 арга хэмжээг тусган дүгнэжээ.

Графикт №3 Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийн үнэлгээний байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан хэсгийг 2021, 2022 оноор харьцуулбал:

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”




Эх сурвалж: Аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн судалгаагаар

Графикаас харахад байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох арга хэмжээний хэрэгжилт 2021 онд 62 хувь, 2022 онд 68 хувьтай буюу өмнөх оноос 6 хувийн өсөлттэй байна. Хэрэгжилт 62-68 хувьтай байгаа нь “ковид-19” цар тахлаас шалтгаалсан байна.

Аймгийн Засаг даргатай БОАЖГ-ын дарга гүйцэтгэлийн гэрээнд 7 зорилтын хүрээнд 2021 онд 54 арга хэмжээ, 2022 онд 7 зорилтын хүрээнд 85 арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжилтийг графикаар харуулбал:

График №4 Аймаг, нийслэлийн Засаг дарга БОАЖГ-ын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт



Эх сурвалж: Аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний хэрэгжилт 2021 онд 92.5 хувь, 2022 онд 93.4 хувьтай буюу өмнөх оноос 0.9 хувийн өсөлттэй байна.

БҮЛЭГ 2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хууль, журмын дагуу хэрэгжээгүй байна

Б.1 Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт журмын дагуу хэрэгжихгүй байна.

Б.1.1 Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа БОАЖЯ-нд 2022, 2023 онуудад хүргүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 2.2¹ заалттай нийцэхгүй байна.

Б.1.2 Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/2, 2022 оны 6/1 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөцийн орлогыг баталсан байна. БНАТ-ийн орлогоос БОХНС арга хэмжээнд зарцуулах доод дүн, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

/сая төгрөгөөр/

№	Байгалийн нөөцийн төрөл	Аймгийн ИТХ-аас баталсан орлого			БНАТ-ийн орлогоос БОХНС арга хэмжээнд зарцуулах доод дүн			СТСХ-ийн гүйцэтгэлээр БНАТ зарцуулсан гүйцэтгэл	
		2021 он	2022 он	2023 он	2021 он	2022 он	2023 он	2021 он	2022 он
		төлөвлөгөө	төлөвлөгөө	төлөвлөгөө					
1	Газрын төлбөр	9,494.80	600.0	-	1,424.2	90.0	-	-	90.0
2	Ан агнуурын нөөц ашигласны орлого	-	-	-	-	-	-	-	-
3	Ус, рашаан ашигласны төлбөр	19,000.0	18,500.0	16,000.0	6,650.0	6,475.0	5,600.0	6,057.6	7,564.7
4	Ургамал ашигласны төлбөр	-	-	-	-	-	-	-	-
Дүн		28,494.8	19,100.0	16,000.0	8,074.2	6,565.0	5,600.0	6,057.6	7,654.7

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн судалгаагаар

Хүснэгтээс харахад аймгийн ИТХ-аас 2022 оны төсөв батлахдаа хуульд заасан зарцуулах доод хэмжээ болон төлөвлөгөөг баримтлахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тогтоосон байна.

Сумдын БНАТ-ийн орлогоос БОХНС арга хэмжээнд зарцуулах доод дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

№	Байгалийн нөөцийн төрөл	ИТХ-аас баталсан орлого, гүйцэтгэл			БНАТ-ийн орлогоос БОХНС арга хэмжээнд зарцуулах доод дүн		
		2021 он	2022 он	2023 он	2021 он	2022 он	2023 он
		төлөвлөгөө	төлөвлөгөө	төлөвлөгөө			
1	Газрын төлбөр	5,522.8	12,524.5	11,250.0	828.4	1,878.7	1,687.5
2	Ан агнуурын нөөц ашигласны орлого	149.4	-	629.1	74.7	-	314.6
3	Ус, рашаан ашигласны төлбөр	30.4	40.5	38.0	10.6	14.2	13.3
4	Ургамал ашигласны төлбөр	-	-	-	-	-	-
Дүн		5,702.6	12,565.0	11,917.1	913.8	1,892.9	2,015.4

¹ Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн судалгаагаар

Сумд 2021 онд 913.8 сая, 2022 онд 1,892.9 сая төгрөгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд хууль журмын дагуу батлуулаагүй байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4², Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.4³ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

2023 онд Засаг даргын Тамгын газрын бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардалд бөөн дүнгээр батлуулан Засаг даргын захирамжаар зардал гарах тухай бүрд нь зарцуулахаар төлөвлөсөн байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 1.2⁴ дах заалттай нийцэхгүй байна.

Засгийн газрын 2 дугаар тогтоолын дагуу БНАТ-1, БНАТ-3, БНАТ-5 тайлангуудыг гаргаж холбогдох газруудад нь хүргүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын 2.5⁵, 2.6⁶, 2.7⁷ заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” -ыг бүрэн хэрэгжээгүй байна. Зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг дарга, БОАЖГ-т албан шаардлага хүргүүлсэн.

Б.1.3 Аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөг үндэслэн 2021-2023 онд тусгай зориулалтаар агнах амьтдын тоог БОАЖ-ын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/701, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/208, 2023 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн А/105 дугаар тушаалаар батлан олгосон байна.

Агнах амьтдын тоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

№	Сумдын нэр	2021 онд агнах ан амьтад		2022 онд агнах ан амьтад		2023 онд агнах ан амьтад
		Угалз	Тэх	Угалз	Тэх	Цагаан зээр
1	Ноён	2	4	3	4	
2	Ханбогд	2	2	3	4	
3	Номгон	1	5	4	8	
4	Хүрмэн	1	4	4	11	
5	Мандал-Овоо	3	2	5	2	
6	Манлай	2		2	0	
7	Баяндалай			0	3	

² Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”,

³ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно

⁴ “Төлбөрийн орлогын хэсгийг төлөвлөх, тайлагнахад энэ журмын хавсралт маягтуудыг (цаашид “БНАТ маягт” гэх) ашиглах бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35.1.17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд цахимаар байршуулна.

⁵ Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

⁶ Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-3 маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна.

⁷ Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 2.5, 2.6-д заасан нийт орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж, аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

Дүн	11	17	21	32	4
-----	----	----	----	----	---

Эх сурвалж: БОАЖ-ын сайдын 2021, 2022 оны тушаалаас

Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрлийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу олгодог байна.

Ус ашиглах дүгнэлтийг 2021 онд 41 аж ахуйн нэгжид, 2022 онд 54 аж ахуйн нэгжид олгосон байна. /Хавсралт-1/

Б.1.4 Газрын төлбөрийн орлогын саналыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг үндэслэн ногдуулалт хийж жил бүр аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлдэг байна.

Ус, рашаан нөөц ашигласны төлбөрийн орлого тооцохдоо өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэдэг байна.

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр	2021 он			2022 он			2023 он		
		Ногдуулалт	СЯ хянасан	Гүйцэтгэл	Ногдуулалт	СЯ хянасан	Гүйцэтгэл	Ногдуулалт	СЯ хянасан	Гүйцэтгэл
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	14,887.0	19,030.3	13,934.5	16,806.2	18,540.5	18,606.9	-	16,037.9	7,002.8
2	Газрын төлбөр	8,811.9	15,017.6	7,877.0	13,124.5	13,111.6	11,772.1	12,000.0	12,250.0	3,260.6
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	0	149.4	360.2	802.3	0	821.7	0	629.0	0
4	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0	0	11.4	0	0	0	0	0	0

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн судалгаагаар

Хүснэгтээс харахад ус рашаан нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 4,143.3 сая, 2022 онд 1,734.3 сая төгрөгөөр, Газрын төлбөрийн орлогыг 2021 онд 6,205.7 сая төгрөгөөр тус тус Сангийн яамнаас үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталсан нь төсвийн орлого тасрахад нөлөөлсөн байна.

Цаашид бодит тооцоонд суурилсан ногдуулалт, өмнөх оны гүйцэтгэл, төсөөллийг үндэслэн төсвийн орлогыг баталж байх шаардлагатай байна.

Усны төлбөрийн ногдуулалтыг аймгийн Татварын хэлтэстэй тулган баталгаажуулахад 2021, 2022 онд 9 аж ахуйн нэг буюу 48.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, татварын албанд төлбөрийн ногдуулалтын тайлан илгээгүй байна. /Хавсралт-2/

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1⁸ заалттай нийцэхгүй байна.

Усны орлогын ногдуулалтыг Аймгийн СТСХ, Татварын хэлтэстэй тулган баталгаажуулахад 318.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна. ТЕГ-аас ирүүлсэн унд ахуйн усыг аж ахуйн нэгжээр бус сумдын ЗДТГ-ын нэрээр шивсэн тул тайлан мэдээ зөрүүтэй тайлагнах, тулган баталгаажуулалт хийх боломжгүй байлаа.

⁸ сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна”, 23.2 “байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

Мөн татварын албанд аж ахуйн нэгжүүд төлбөрийн ногдуулалтын тайланг хүргүүлэхдээ үнийн дүн зөрүүтэй илгээх, илгээхгүй байх зөрчил түгээмэл байна. Иймд хууль, журамд өөрчлөлт оруулан ногдуулалтын тайланг үнэн зөв хугацаанд нь сумын байгаль хамгаалагчаар татварын албанд хүргүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлэх нь зүйтэй байна.

Б.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 16.1 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна

Б.2.1 Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд гүйцэтгэсэн 130 арга хэмжээнээс 105 арга хэмжээ нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдаж 25 арга хэмжээ буюу 24.6 хувийг менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. /хавсралт-3/

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтад оруулах талаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт №6 Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд хийсэн 130 арга хэмжээний 105 арга хэмжээ нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдаж 25 арга хэмжээ /сая төгрөг/

№	Байгалийн нөөцийн төрөл	Огноо	Төсөвт төвлөрүүлсэн орлого	БНАТ-д зарцуулсан	Төлбөрийн орлогын эзлэх хувь	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөөнд	
							Тусгасан арга хэмжээ	Тусгаагүй арга хэмжээ
1	Ойн нөөц	2021	0	0	0	0	0	
2		2022	0	0	0	0	0	
3	Ан амьтны нөөц	2021	360.2	257.2	71.4	6	6	
4		2022	821.8	219.4	26.7	7	7	
5	Усны нөөц	2021	13,934.50	5,253.90	37.7	32	28	
6		2022	18,606.90	6,937.50	37.3	68	47	
7	Ургамлын нөөц	2021	11.4	0	0.0	0	0	
8		2022	2.6	19.5	750.0	1	1	
9	Газрын нөөц	2021	7,876.90	546.4	6.9	5	5	
10		2022	11,771.20	478.3	4.1	11	11	
Нийт дүн			53,385.5	13,712.2		130	105	

Эх сурвалж: Өмнөговь аймгийн 2021-2025 оны ан агнуурын менежментийн ерөнхий төлөвлөгөө, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Галба өөш, долоодын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний арга хэмжээ, алтайн өвөр говийн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө

Энэ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.4⁹ заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт № 7 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 2021-2022 оны гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Огноо	БНАТ-ын гүйцэтгэл	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	СТСХ-ийн гүйцэтгэлээр БНАТ зарцуулсан гүйцэтгэл	Хуулийн хэрэгжилт
1	2021	22,183.2	8,989.7	6,057.5	67.4%
2	2022	31,202.6	8,458.2	7,654.7	90.5%
Нийт дүн, дундаж хувь		53,385.8	17,447.9	13,712.2	78.9%

Эх сурвалж: Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн судалгаагаар

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2022 оны гүйцэтгэл 53,385.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд 13,712.4 сая төгрөг зарцуулж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын гүйцэтгэлийн дундаж хувь 78 хувь болж, 2021 оны гүйцэтгэлээс 23 хувиар өссөн байна.

⁹13.4.Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

График №5 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2021-2022 оны зарцуулалтын эзлэх хувь




Эх сурвалж: Аймгийн төрийн сангийн хэлтсийн мэдээгээр

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 2021-2022 оныг нэгтгэн дүгнэхэд 33 арга хэмжээнд 3,195.3 сая төгрөг буюу 23.3 хувийг ойн нөөц, 1 арга хэмжээнд 19.5 сая төгрөг буюу 0.1 хувийг ургамлын нөөц, 13 арга хэмжээнд 476.7 сая төгрөг буюу 3.4 хувийг ан, амьтны нөөц, 67 арга хэмжээнд 8,996.1 сая төгрөг буюу 65.8 хувийг усны нөөц, 16 арга хэмжээнд 1,024.8 сая төгрөг буюу 7.4 хувийг газрын нөөцөд тус тус зарцуулсан байна.

Б.2.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардалд 2021-2022 онд 13,712.4 сая төгрөг буюу 130 арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Хэрэгжүүлсэн 32 арга хэмжээ буюу 16.1 хувийг журамд заагаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.

График №6 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд төсвийг зориулалт бусаар зарцуулсан гүйцэтгэлийн хувь /сая төгрөг/




Эх сурвалж: Аймгийн төрийн сангийн хэлтсийн мэдээгээр

Үүнээс ойн нөөцөд 1 арга хэмжээ буюу 60.1 сая төгрөг, усны нөөцөд 31 арга хэмжээ буюу 2,152.7 сая төгрөгийг усны нөөцөөс зориулалт бусаар төсөвт байгууллагын урсгал зардал, хог хаягдал, аялал жуулчлал, авто машин, бусад хөтөлбөр, төсөл арга хэмжээнд тус тус зарцуулсан байна. /Хавсралт-4/

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

График №7 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлаас зориулалт бусаар санхүүжүүлсэн арга хэмжээний эзлэх хувь /сая төгрөг /



Эх сурвалж: Аймгийн төрийн сангийн хэлтсийн мэдээгээр

Дээрх зөрчлийг арилгуулах тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Монгол улс усны нийт хэрэглээний 80 орчим хувь тэр дундаа говийн бүсэд 100 хувь газрын гүний усаар хангаж байна.

Салбарын эрдэмтэд уул уурхайн усны хэрэглээний талаар “Говийн бүс дэх газар доорх усны ордууд усны нөхөн сэлбэгдэх чадвар муутай, усны нөөцийг урт хугацаанд тасралтгүй ашиглах бол усны түвшин нь буурах, шавхагдах, эрсдэлтэй, усны ууршилт өндөртэй, цөлжих аюул дагуулна. Ийм эрсдэл нь цаашид бүс нутгийн хэмжээнд хуурайшилт бий болох 2025 он гэхэд говь нутагт усны хомсдол нүүрлэж, уул уурхай байтугай жирийн иргэдийн амьдралд хүндрэлтэй зүйлүүд тулгарч болзошгүй байгааг анхааруулдаг.

Иймээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг зориулалтын дагуу зарцуулах, үүний дотор газар доорх усны ордын нөхөн сэлбэгдэх бодит боломж, тэжээмжинд уялдуулсан усны хэрэглээг гаргах тооцоо судалгаа хийх, саарал усыг ашиглах, ус цэвэршүүлэх технологийн нэвтрүүлэхэд чиглэсэн төсөл арга хэмжээ санхүүжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3 Хуулийн хэрэгжилтэд хийх хяналт, шалгалт хангалтгүй байна.

В.1 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна

В.1.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлыг цахим мэдээллийн санд байршуулна гэж заасан байдаг. Өмнөговь аймгийн хувьд байгалийн нөөцийн ус рашаан, байгалийн ургамал, амьтны гэсэн 3 төрөлд мэдээлэл бүрдүүлэлтийг авч үзсэн.

Аймгийн БОАЖГ-аас <http://eic.mn/finance/> цахим системд төлөвлөлтийн хэсгийн 6 маягт, гүйцэтгэлийн хэсгийн 4 маягт нийт 12 маягтаар тухайн жилийн мэдээг оруулахаар заасан байдаг.

Аудитаар 2022 оны мэдээ бүрдүүлэлтийг үзэхэд маягыг бөглөхгүй хоосон хаах, оруулсан мэдээнд нөөцийн зарим төрлийг орхигдуулах, буруу мэдээлэх зэрэг зөрчил гарч байна. Цахим системд мэдээллийг журмын дагуу оруулж ажиллах талаар аймгийн БОАЖГ-т албан шаардлага хүргүүлсэн.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

Энэ нь Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-аар зохицуулагдаж байгаа бөгөөд тус журмын хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Хүснэгт № 8 <http://eic.mn/finance/> цахим системийн мэдээ оруулалтын байдал

Д/д	Маягтын дугаар	Мэдээний нэр	Журамд заагдсан хугацаа сар/өдөр	Мэдээлсэн эсэх /тийм, үгүй/	Нөөцийн төрлөөр мэдээлсэн байдал /тийм, үгүй/			тайлбар
					Ус, рашаан	Ургамал	Амьтан	
Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системийн төлөвлөлтийн мэдээ								
1	Маягт 3	Аймгийн төсөвт төвлөрүүлэх БНАТ-ийн орлогын төлөвлөгөө	VII/25	тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу
2	Маягт 4А	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий төлөвлөгөө		тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу
3	Маягт 5	Аймгийн БНАТ-ийн нийт орлогын төлөвлөгөө	VIII/01	тийм	үгүй	үгүй	үгүй	маягт бөглөөгүй хаасан
4	Маягт 6А	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНС нийт арга хэмжээний төлөвлөгөө		тийм	үгүй	үгүй	үгүй	маягт бөглөөгүй хаасан
5	Маягт 4Б	Аймгийн БНАТ-ийн давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий төлөвлөгөө	XI/15	тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу
6	Маягт 6Б	Аймгийн БНАТ-ийн давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНС нийт арга хэмжээний төлөвлөгөө	XI/20	үгүй	-			мэдээ оруулаагүй
7	Маягт 4	Аймгийн төсвийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий нэгтгэл төлөвлөгөө	XI/20	тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу
8	Маягт 6	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ий нэгтгэл төлөвлөгөө	XI/20	тийм	үгүй	үгүй	үгүй	маягт бөглөөгүй хаасан
Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системийн гүйцэтгэлийн мэдээ								
9	Маягт 9	Аймгийн төсөвт төвлөрүүлсэн БНАТ-ийн орлогын гүйцэтгэл тайлан	I/15	тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу
10	Маягт 10	Аймгийн төсөвт төвлөрүүлсэн БНАТ-ийн орлогын хэсгийн зарцуулалтын тайлан		тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу
11	Маягт 11	Аймгийн БНАТ-ийн нийт орлогын гүйцэтгэлийн тайлан	I/20	тийм	үгүй	үгүй	үгүй	маягт бөглөөгүй хаасан
12	Маягт 12	Аймгийн БНАТ-ийн орлогын хэсгийн нийт зарцуулалтын тайлан		тийм	тийм	үгүй	үгүй	бүрдэл дутуу

Эх сурвалж: аймгийн БОАЖГ-аас <http://eic.mn/finance/> цахим мэдээллийн санд оруулсан 2022 оны мэдээ

Уг системд сумдын оруулах мэдээллийн хувьд тухайн оны төлөвлөлтийн 4 маягт, гүйцэтгэлийн 2 маягт нийт 6 маягтаар мэдээ оруулах байснаас 2022 онд Баяндалай сум 1 маягтаар зөвхөн усны мэдээг оруулсан байна.

В.1.2 Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нь санхүү, төрийн сангийн мэдээ, татварын газрын мэдээ, БОАЖГ-ын <http://eic.mn/finance/> цахим системд оруулсан мэдээнүүд хоорондоо зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагын хамтын ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл			Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын гүйцэтгэл	
Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Татварын газрын мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд орлогын гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн	Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн зарцуулалтын гүйцэтгэлийн дүн	Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд зарцуулсан гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн
18,606.9	18,729.5	6,750.0	6,937.5	7,654.7

Эх сурвалж: <http://eic.mn/finance> цахим мэдээллийн сангийн мэдээ, аймгийн төрийн сангийн мэдээ, татварын газрын мэдээ

Мөн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлыг <http://eic.mn/finance/> цахим систем, татварын газрын цахим систем, санхүү төрийн сангийн цахим мэдээллийн сан зэрэг системүүд нь тус тусдаа ажиллагаатай хоорондоо холбоогүй байдаг нь мэдээллийн зөрүү гарч байгаагийн нэг шалтгаан болж байна.

В.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт, хийж үр дүнг дүгнээгүй байна.

3.3 Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын яам 2022 оны хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Тус тайлангийн дүгнэлтэд

- eic.mn/finance/ цахим системд мэдээг нутгийн өөрөө удирдах байгууллагад танилцуулаагүй, мэдээллийн бүрдэл дутуу, худал тайлагнасан,
- аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлыг бүрэн батлаагүй,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ангиллын зардлын зарцуулалтын 40 хувь нь зориулалт бус байгаа талаар тус тус тусгасан байна.

3.4 Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг авч ажиллахыг тусгасан байна.

Гэвч нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар 2021-2023 онд ямар нэгэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгээгүй байна.

Томоохон уул уурхайн орд газрууд үйл ажиллагаа явуулдаг, усны хэрэгцээгээ гүний усаар хангадаг бүс нутгийн хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс ус ашиглалтын талаар онцгой анхаарч үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгийг баталж хэрэгжүүлсэн байна,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хууль, журмын дагуу хэрэгжээгүй байна,
- Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 16.1 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна,
- Татварын албанд аж ахуйн нэгжүүд төлбөрийн ногдуулалтын тайланг хүргүүлэхдээ үнийн дүн зөрүүтэй илгээх, илгээхгүй байх зөрчил түгээмэл байна,
- Цахим системд оруулсан мэдээллийн бүрдэл, үнэн зөв байдал хангалтгүй байна,
- Ус, рашаан ашиглалтын талаарх төрийн байгууллагуудын мэдээлэл зөрүүтэй байна,
- Хуулийн хэрэгжилтэд нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс хяналт хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

- Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх,
- Томоохон уул уурхайн орд газрууд үйл ажиллагаандаа гүний ус ашиглаж байгаад онцгой анхаарч үр дүнтэй ажил зохион байгуулах,

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/17

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 10 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг ахлах аудитор (Д.Сүрэнжаргал)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР

ХАВСРАЛТ № 1

/сая төгрөгөөр/

2021-2022 усны мэдээлэл

№	Газрын нэр	2021 он				2022 он			
		Ашиглагчийн тоо	Ашиглах усны хэмжээ, м3 /дүгнэлтэд заасан хэмжээ/	Ашигласан усны хэмжээ, м3 /ногдуулалтаар/	Ашигласан усны төлбөр, төлбөл зохих, төгрөг /ногдуулалтаар/	Ашиглагчийн тоо	Ашиглах усны хэмжээ, м3 /дүгнэлтэд заасан хэмжээ/	Ашигласан усны хэмжээ, м3 /ногдуулалтаар/	Ашигласан усны төлбөр, төлбөл зохих, төгрөг /ногдуулалтаар/
1	Аймгийн БОАЖГ	23	211,368.27	211,368.27	19.3	32	240363	240363	32.0
2	Галба-Өөш-Долоодын Говийн сав газрын захиргаа	10	30,478,768.4	15,989,481.6	14,078.3	12	29,479,228.8	16,883,663.9	15,716.7
3	Алтайн Өвөр Говийн сав газрын захиргаа	7	2,069,440	733,861	789.5	8	2,715,442	1,124,595	1,057.5
4	Онги даацын сав газар	1	550,000	65,550	6.4	2	902,158	401,958	24.4
ДҮН		41	33,309,576.30	17,000,260.32	14,893.50	54	33,337,192.09	18,650,579.5	16,830.60

ХАВСРАЛТ № 2

Татварын газрын тулгалтаар

ДД	Сумын нэр	Огноо	Ашиглагчийн нэр	Төлбөл зохих төлбөрийн дүн /ногдуулалт/		Төлсөн төлбөрийн дүн		Төлөөгүй дүн	Тайлбар
				Ногдуулалт	Татварын тайлангаар	Үйлдвэр	Унд ахуй		
1	Даланзадгад	2021	Сан ХХК	33,096.0	-		-	33,096.0	татварт тайлан ирүүлээгүй
2	Баян-Овоо	2021	Ямаат борзон ХХК	276,158.0	-			276,158.0	татварт тайлан ирүүлээгүй
3	Баян-Овоо	2021	Шижир баялаг ХХК	276,158.0	-			76,158.0	татварт тайлан ирүүлээгүй
4	Баян-Овоо	2021	Хардэл бэйс ХХК	819,615.0	-			819,615.0	татварт тайлан ирүүлээгүй
5	Баян-Овоо	2021	Алтан рио ресурс ХХК	276,158.0	-			276,158.0	татварт тайлан ирүүлээгүй
6	Манлай	2021	Цайна инвестмент монголиа ХХК	69,102.0	-			69,102.0	татварт тайлан ирүүлээгүй
7	Баяндалай	2021	Цайна инвестмент монголиа ХХК	116,475.0	-		-	116,475.0	татварт тайлан ирүүлээгүй
8	Ханбогд	2022	Херуга эксплорэйшн ХХК	2,219,684.0	-		266,168.00	1,953,516.0	татварт тайлан ирүүлээгүй
9	Гурвантэс	2022	Жавхлант орд ХХК	44,525,117.82	-	35,099,117.82		44,525,117.8	Тайлант онд ногдол байхгүй. 2021 оны мөнгийг төлсөн.
ДҮН				48,611,563.8				48,345,395.82	

ХАВСРАЛТ № 3

Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар хийсэн менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээ

Д/д	Огноо	Байгалийн нөөцийн төрөл	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй зарцуулсан дүн
1	2021	Ойн нөөц	Ой, ойн хамгаалал	Далан булгийн цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулах /нэмэлт ажил/	60.0
2	2021	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Даланзадгад сумын шинэ цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд инженер, техникийн ажилчдын цалин урсгал зардалд	200.0
3	2021	Усны нөөц	Аялал жуулчлал	Ай Ти Эм Монголиа 2021 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас холбогдох байгууллагуудыг оролцуулах	9.0
4	2021	Усны нөөц	Аялал жуулчлал	Хямд амар аялал жуулчлалын цахим үзэсгэлэнд оролцох	4.9
5	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ	10.0
6	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Түмэн тэмээний баяр-22 арга хэмжээ	36.9
7	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Улаанбаатар экспо-2022 аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас холбогдох байгууллагуудыг оролцуулах	9.0
8	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Сайханы сарлаг-2022 арга хэмжээг зохион байгуулах	9.9
9	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Байгалийн үзэсгэлэнт газар, түүхийн олдвор бүхий газруудын сурталчлан таниулах апплейкэшн суурилуулах	26.0
10	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Нүүдэлчдийн нэг өдөр" арга хэмжээ	8.0
11	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн эвент болох Элсэн манхны баяр -2022 арга хэмжээг зохин байгуулахад шаардагдах зардал	40.0
12	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	"Элсэн манхны баяр 2022" арга хэмжээнд элсэн баримал хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх/ Мөнх-Эрдэнэ, Ууганцэцэг/	25.0
13	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Өмнөговь аймгийн үзэсгэлэнт газрууд, аялал жуулчлалын бүсийг олон улсад болон БНСУ-д сурталчлан таниулах, Солонгос улсын KBS телевизтэй хамтран ажиллах зардал	8.6
14	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	"Домгийн говь- Өмнөговь 100 км" уртын явган аяллын арга хэмжээг хамтран зохион байгуулах	15.0
15	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	"ITM-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох зардал	14.5
16	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Онгийн гол, Улаан нуурын мөсний баяр-22 арга хэмжээ	6.0
17	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Байгаль хамгаалагчид судалгаа шинжилгээ хийх, эргүүл пост гаргахад ашиглах зөөврийн сууц худалдан авах	18.0
18	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	БОАЖГ-ыг бүрэн тоноглогсон автомашин Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдын байгаль хамгаалагч нарыг албаны автомашинаар хангах ажил	204.9
19	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Алтайн өвөр говь сав газрын захиргааг туулах чадвар сайтай автомашинаар хангах	130.0
20	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааг өөрөө явагч хэрэгслээр хангах	46.8

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

21	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Булган сумын цаг уурын өртөөний барилгын дотоод засвар	10.0
22	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Баян-Овоо сумын хөдөө, аж ахуйн цаг уурын харуулд тоног төхөөрөмжийн шинэчлэл	10.0
23	2022	Усны нөөц	Ой, ойн хамгаалал	Сумдын нийтийн ногоон байгууламжийн талбайн ашиглалт хамгаалалтыг сайжруулах хүрээнд усалгааны авто машинаар хангах	232.5
24	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	ХААИС-ийн Агро экологийн сургуулийн "Экологи , байгаль хамгаалал" бакалаврын эчнээ ангид суралцагчдын сургалтын төлбөр, багш нарын зардал	24.0
25	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх , мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг бүхий албан хаагчийн ажлын байр, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зардал	41.4
НИЙТ ДҮН					1,200.4

ХАВСРАЛТ № 4

Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар хийсэн зориулалт бус арга хэмжээ

Д/д	Огноо	Байгалийн нөөцийн төрөл	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй зарцуулсан дүн
1	2021	Ойн нөөц	Ой, ойн хамгаалал	Далан булгийн цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулах /нэмэлт ажил/	60.0
2	2021	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Гэр хорооллын айл өрхөд зориулалтын хог хаягдлыг ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлэх	49.2
3	2021	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Даланзадгад сумын шинэ цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд инженер, техникийн ажилчдын цалин урсгал зардалд	200.0
4	2021	Усны нөөц	Аялал жуулчлал	Ай Ти Эм Монголиа 2021 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас холбогдох байгууллагуудыг оролцуулах	9.0
5	2021	Усны нөөц	Аялал жуулчлал	Хямд амар аялал жуулчлалын цахим үзэсгэлэнд оролцох	4.9
6	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ	10.0
7	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Түмэн тэмээний баяр-22 арга хэмжээ	36.9
8	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Улаанбаатар экспо-2022 аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгаас холбогдох байгууллагуудыг оролцуулах	9.0
9	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Сайханы сарлаг-2022 арга хэмжээг зохион байгуулах	9.9
10	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Байгалийн үзэсгэлэнт газар, түүхийн олдвор бүхий газруудын сурталчлан таниулах апплейкэшн суурилуулах	26.0
11	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Нүүдэлчдийн нэг өдөр" арга хэмжээ	8.0
12	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн эвент болох Элсэн манхны баяр -2022 арга хэмжээг зохин байгуулахад шаардагдах зардал	40.0
13	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	"Элсэн манхны баяр 2022" арга хэмжээнд элсэн баримал хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх/ Мөнх-Эрдэнэ, Ууганцэцэг/	25.0
14	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Өмнөговь аймгийн үзэсгэлэнт газрууд, аялал жуулчлалын бүсийг олон улсад болон БНСУ-д сурталчлан таниулах, Солонгос улсын KBS телевизтэй хамтран ажиллах зардал	8.6
15	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	"Домгийн говь-Өмнөговь 100 км" уртын явган аяллын арга хэмжээг хамтран зохион байгуулах	15.0
16	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	"ITM-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох зардал	14.5
17	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Онгийн гол, Улаан нуурын мөсний баяр-22 арга хэмжээ	6.0

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”

18	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Байгаль хамгаалагчид судалгаа шинжилгээ хийх, эргүүл пост гаргахад ашиглах зөөврийн сууц худалдан авах	18.0
19	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	БОАЖГ-ыг бүрэн тоноглогдсон автомашин Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдын байгаль хамгаалагч нарыг албаны автомашинаар хангах ажил	204.9
20	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Алтайн өвөр сав газрын захиргааг туулах чадвар сайтай автомашинаар хангах	130.0
21	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааг өөрөө явагч хэрэгслээр хангах	46.8
22	2022	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Орчин үеийн технологийн шийдлийг ашигласан хог хаягдал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ	30.8
23	2022	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Даланзадгад сумын хогийн төвлөрсөн цэгийг хашаажуулах ажил	222.6
24	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Булган сумын цаг уурын өртөөний барилгын дотоод засвар	10.0
25	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Баян-Овоо сумын хөдөө, аж ахуйн цаг уурын харуулд тоног төхөөрөмжийн шинэчлэл	10.0
26	2022	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Даланзадгад сумын Захирагчийн ажлын албанд хог түрж булшлах бульдозер, цахилгааны хөдөлгүүртэй зам цэвэрлэгээний автомашин нийлүүлэх	541.0
27	2022	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Номгон сумын суманд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	49.9
28	2022	Усны нөөц	Хөрс, агаар, орчны бохирдлын эсрэг	Сэврэй суманд хог хаягдал нийлүүлэх автомашин нийлүүлэх ажил	99.0
29	2022	Усны нөөц	Ой, ойн хамгаалал	Сумдын нийтийн ногоон байгууламжийн талбайн ашиглалт хамгаалалтыг сайжруулах хүрээнд усалгааны авто машинаар хангах	232.5
30	2022	Усны нөөц	Аялал жуулчлал	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын нэгдсэн цахим мэдээллийн сан үүсгэх ажил	19.8
31	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	ХААИС-ийн Агро экологийн сургуулийн "Экологи , байгаль хамгаалал" бакалаврын эчнээ ангид суралцагчдын сургалтын төлбөр, багш нарын зардал	24.0
32	2022	Усны нөөц	Байгаль хамгаалал	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх , мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг бүхий албан хаагчийн ажлын байр, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зардал	41.4
НИЙТ ДҮН					2,212.7